

МОНГОЛ, СОЛОНГОС ЭМ ЗҮЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Б.Солонго, Ч.Баярбахдал, М.Маргад, Ц.Соёл-Эрдэнэ, Д.Байгалмаа
ЭЗШУИС, Эмийн Үйлдвэрийн Инженер Технологийн тэнхим*

COMPARATIVE STUDY OF PHARMACISTS IN MONGOLIA AND KOREA

*Solongo B, Bayarbakhdal Ch, Margad M, Soyol-Erdene Ts, Baigalmaa D
Department of Pharmaceutical Engineering and Technology, MUPS
baigalmaa.d@monos.mn*

Introduction: Now days in case of two countries' cooperation has been developing day by day, diversified activities such as collaboration and exchanging experience has been performing in health sector, medical science, besides pharmacology.

Methods: This study aimed to compare two countries' pharmacist's acquirements and roles and provide information to Mongolian Pharmaceutical Universities and pharmacist students.

Pharmaceutical: Statistics

Population:

- 3 million in Mongolia
- 5 million in Korea

Number of pharmacists:

- 1726 (by 2016) in Mongolia
- 33182 (by 2016) in Korea

Number of Pharmaceutical Universities

- 7 universities, including 1 public and 6 private in Mongolia
- 34 universities, including 10 public and 25 private in Korea

Results:

As a result of this study, pharmacist's acquirements, role and working sectors of pharmacists in two countries are ordinarily same. There are some different sides below:

- Period of pharmacist's preparatory training is 5 years at university in Mongolia and 2+4 years in Korea.
- Pharmaceutical Universities of Mongolia trains 2 specialists: pharmacist (bachelor's degree) and pharmacist (diplom's degree); College of Pharmacy of Korea trains pharmacist, pharmacist of traditional medicine and pharmaceutical engineering.
- For a role of business, in Mongolia pharmacist (diplom's degree) is a separate specialist trained with diploma, whereas in Korea, if pharmacist gets a license, they have a right to compound a medicine legally, but commonly in pharmaceutical industry.
- As for sector, pharmacists are trained in many specializes, such as general pharmacist, clinical pharmacist, military pharmacist, nuclear pharmacist, cancer pharmacist and vet pharmacist.
- Special legal professional pharmacists work in Korea, such as governmental organization's pharmacist, civil service pharmacist and public organization's pharmacist.

- No person, other than pharmacists or oriental pharmacists may dispense drugs, and pharmacists or oriental pharmacists shall dispense drugs within the limit of the license, respectively: However, students who major in pharmacy at college may dispense drugs within the limits prescribed by Ordinance of the Ministry of Health and Welfare.

Үндэслэл

Монгол-Солонгос хоёр орны хамтын ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин тэлж буй өнөө цагт хоёр орны эрүүл мэнд, анагаах ухаан, эм зүйн салбарт ч бас хамтран ажиллах, харилцан туршлага солилцох зэрэг олон талт үйл ажиллагаа хэрэгжиж байна. Энэхүү судалгаа нь хоёр орны эм зүйч мэргэжлийн онцлог, мэдлэг боловсрол, ажил үүргийн талаар харьцуулан үзэж, Монголын эм зүйн сургуулиуд болон суралцагчдад мэдээлэл хүргэх зорилго тавилаа.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн:

- Монгол, Солонгос хоёр орны эмзүйн мэргэжлийн талаарх статситик мэдээ
- Хоёр орны эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эмзүйч мэргэжлийн тухай хууль, дүрэм журам

Арга аргачлал: Монгол, Солонгос хоёр орны эм зүйч мэргэжилтэний мэргэжлийн тодорхойлолт, мэргэжлийн шаардлага, эм зүйн боловсролын тогтолцоо, мэргэжлийн салбар, ажил үүргийн тухай мэдээллийг нэгтгэн дүгнэж, харьцуулан судлах аргыг ашиглав.

Судалгааны ажлын үр дүн:

Статистик мэдээ

1. Хүн ам:

Монгол 3 сая, Солонгос 50 сая хүн амтай.

2. Эм зүйчийн тоо (2016 он):

- Монголд 1726

- Солонгост 33182 эм зүйч ажиллаж байна.

/1000 хүн амд ноогдох эм зүйчийн тооны харьцаа Монголд 5, Солонгост 6 эм зүйч ноогдож байна./

3. Эм зүйн их сургуулийн тоо (2017он):

- Монгол Улсад эм зүйч бэлтгэж буй 7 их, дээд сургууль байна. Үүнд: Улсын сургууль-1 (АШУҮИС-ийн Эм зүйн сургууль), хувийн сургууль -6 (ЭЗШУИС, Шинэ анагаах ухааны ИС, Этүгэн дээд сургууль, Энэрэл дээд сургууль, МҮИС, Оточ Манрамба ИС) тус тус байна.

- БНСУ-д нийт 35 эм зүйн сургуультай. (Улсын 10, хувийн 25 сургууль)

Эм зүйчийн мэргэжлийн тодорхойлолт:

Монгол:

- Эм зүйч нь эм зүйн ухааны бакалаврын боловсролыг эзэмшиж, эм барих зөвшөөрөл авсан, эмийн бодисын үйлдлийн механизм, хэрэглэх заалт, гаж нөлөөний талаарх эмнэлзүйн суурь мэдлэгтэй, эм үйлдвэрлэх технологи, эмийн чанарын баталгаажуулалт, сорилт, шинжилгээ хийх, эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын

аргыг эзэмшсэн, хүн амд эм зүйн тусламж, үйлчилгээг ёс зүйн, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх онол арга зүй, эрдэм шинжилгээ судалгааны ажлын мэдлэгтэй мэргэжилтэн байна.

Солонгос:

- Эм зүйч гэдэг нь эм, эмийн бүтээгдэхүүн, эм төст бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, найруулах, хяналт тавих, хадгалах, импортлох, худалдах болон түүнээс бусад эмийн технологитой холбоотой үйлчилгээг гүйцэтгэх мэргэжилтэн байна.
- Эмзүйч нь уламжлалт эмээс бусад эм зүйчийн ажил үүргийг хариуцах ба уламжлалт эм зүйч нь уламжлалт эм барихтай холбоотой эм зүйчийн ажил үүргийг гүйцэтгэнэ. Эм зүйч болон уламжлалт эм зүйч нь тус тусдаа Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны сайдын зөвшөөрөлтэй байна.

Эм зүйч мэргэжлийн шаардлага:

Монгол Улс:

Хүн амд эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхтэй холбогдох асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах эмийн бодисын үйлдлийн механизм, хэрэглэх заалт, гаж нөлөөний талаар эм зүйн суурь мэдлэгтэй, эмийн үйлдвэрийн технологи, эмийн чанарын баталгаажуулалт, эрдэм шинжилгээний суурь мэдлэг эзэмшсэн эмийн талаар төрөөс баримтлах бодлого болон дэлхийн эм зүйн хандлагын талаар мэдлэгтэй байх, Эм зүйчийн лицензийн шалгалтанд тэнцсэн байх.

Солонгос:

Эм зүйч болохын тулд Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны сайдын зөвшөөрөл буюу Эм зүйн ухааны их сургууль төгсөж эм зүйчийн мэргэжил эзэмшсэн хүн “Эм зүйчийн эрх олгох лиценз”-ийн шалгалтанд тэнцсэн байх шаардлагатай. Үүнээс гадна эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны сайдын зөвшөөрөл бүхий гадаадын Эм зүйн их сургуулийг эм зүйч мэргэжлээр төгссөн хүн Солонгосын “Эм зүйчийн эрх олгох лиценз”-ийн шалгалтанд тэнцэж байж Солонгост эм зүйчээр ажиллах эрх нь нээгдэнэ.

Хоёр улсын Эм зүйн боловсролын тогтолцоо:

Монгол Улс:

- Эм зүйч мэргэжлийг Эм зүйн их сургуульд бакалаврын түвшинд 5 жилийн сургалтаар олгоно. Эм зүйн их сургуулийн оюутан нь Эм зүйч (*бакалаврын зэрэгтэй*), Эм найруулагч (*дипломын зэрэгтэй*) мэргэжлээр төгсдөг.

Солонгос:

- Эм зүйчийн мэргэжлийг Эм зүйн их сургуульд бакалаврын түвшинд 2+4 жилийн сургалтаар олгодог. (2+4 сургалт нь **аль нэг их сургуульд 2 жил суралцаж суурь мэдлэг эзэмшсэн оюутан Эм зүйн их сургуульд элсэн орох шалгалт (PEET) өгч тэнцсэн бол ЭЗИС-д 4 жил суралцаж эм зүйчийн боловсрол эзэмшинэ.**)
- Эм зүйн их сургууль нь эм зүйч, эмийн үйлдвэрийн инженер технологич, уламжлалт эм зүйч гэсэн 3 мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг.

Эм зүйн салбар

Хоёр орны эм зүйн мэргэжилтэн дараах албан үүргийг гүйцэтгэж байна.

Монгол Улс

- Нийтийн үйлчилгээний эмийн санд: Эмийн сангийн эрхлэгч, нөөцийн тасгийн эрхлэгч,

жор баригч, эм шалгагч, эм найруулагч

- Эмнэлгийн эмийн санд: Эмийн сангийн эрхлэгч, чанарын менежер, эм шинжлэгч, нөөцийн тасгийн эрхлэгч, клиникийн эм зүйч, жор баригч, эм найруулагч
- Эмийн үйлдвэрт: Эмийн технологич, менежер, эмийн чанар шалгагч, эм шинжлэгч
- Эм ханган нийлүүлэх байгууллагад: Худалдааны менежер, чанарын менежер, агуулахын эрхлэгч, бэлтгэгч-эм найруулагч, олгогч, захиалга хүлээн авагч- эм зүйч

Солонгос

Эрдэм шинжилгээний ажилтан, клиник эм зүйч, орон нутгийн эмийн сангийн эм зүйч, эм найруулагч, эмнэлгийн эм зүйч, эмийн үйлдвэрийн эм зүйч, жор баригч эм зүйч, зөвлөх эм зүйч, эмийн мэдээллийн эм зүйч, өрхийн эрүүл мэндийн эм зүйч, туслах эм зүйч, цэргийн эм зүйч, цөмийн эм зүйн ухаанаар мэргэшсэн эм зүйч, хорт хавдраар мэргэшсэн эм зүйч, эмнэлзүйн эмгэг судлалын эм зүйч, эмнэлзүйн хор судлалын эм зүйч, эм ханган нийлүүлэх байгууллагад эд хариуцагч төрийн албаны эм зүйч, мал, амьтны эм зүйч

Эм зүйчийн ажил үүрэг: Хоёр орны “Клиник эм зүйч” нь дараах ажил үүргийг гүйцэтгэдэг байна.

Монгол Улс:

- Эмчлэгч эмчтэй зөвшилцөх замаар жор бичилтэнд хяналт тавих, эмнэлгийн бусад мэргэжилтнийг эмийн талаархи мэдээллээр хангана.
- Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн боловсрол олгох, тухайн иргэнд тохирсон эмчилгээ, эмчилгээ, нийгмийн эрүүл мэндийн болон урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн талаар шийдвэр гаргахад шаардагдах мэдээллээр хангана.
- Шаардлагатай тохиолдолд удаан хугацаанд эмчийн хяналт, асаргаанд байгаа үйлчлүүлэгчид зориулсан тусгай өрөөнд эм зүйн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, даралт, биеийн жин шалгах, эмийн хэрэглээний түүхийг хөтлөн жор бичилтийг хянана.
- Эмчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, эмийн хэрэгцээг үнэлэх, эмчилгээг зохицуулахад эмчтэй хамтран ажиллана.
- Үндэсний эмийн лавлах, эмчилгээний стандарт, удирдамжид үндэслэн нотолгоонд суурилсан эмчилгээний арга технологийг нэвтрүүлэхэд оролцоно.
- Эмийн тунг зохицуулах хяналтын параметруудийг багтаасан эмийн зохистой хэрэглээний талаарх нотолгоонд суурилсан мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэнд өгөх, шаардлагатай тохиолдолд эмчийн жор бичилт, эмийн сонголт, зохих тунг сонгоход оролцоно.
- Эмэн эмчилгээний ахиц, үр дүнд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор эмчлүүлэгчийн клиникийн мэдээллийг харах боломжоор хангагдах, ялангуяа олон мэргэжлийн эмч нар эмчилгээнд оролцож байгаа үед хөндлөнгөөс хяналт тавина.
- Эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдийг нянгийн эсрэг бэлдмэлийн зохистой хэрэглээний талаарх мэдээллээр хангаж нянгийн тэсвэртэй байдлыг бууруулах, антибиотиковын зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нянгийн даслаас сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.

Солонгос:

- Өвчтөний эмийн жорыг нягталж, хяналт тавина.
- Оношлогдсон болон оношлогдоогүй өвчтөний биеийн байдалд дүгнэлт хийж эмийн тун

тохирсон эсэхэд хяналт тавина. (бөөрний болон элэгний дутагдалтай өвчтөний эмийн тунг тохируулах г.м/

- Эмнэлгийн ажилтнуудад эм зүйн мэдлэгээр хангана.
- Шинэ эмийн клиник туршилтын багт ажиллаж зөвлөнө.
- Эмчлүүлэгчдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгнө.
- Эмнэлгийн эмийн сангийн туслах эм зүйч, ажилтанд зааж сургана.
- Давтан сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо байнга дээшлүүлнэ.

Хэлцэмж: Дээрх судалгаанаас үзэхэд хоёр орны эм зүйчийн эзэмших боловсрол, ажил үүрэг, ажиллах мэргэжлийн салбар зэрэг нь ерөнхийдөө адил төстэй байна. Үүнээс ялгаатай тал нь дараах болно.

1. Монголын эм зүйн сургууль 5 жилийн сургалтаар эм зүйч бэлтгэдэг бол Солонгост 2+4 жилийн сургалттай байна.
2. Монголын эм зүйн сургуульд эм зүйч, эм найруулагч чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг бол Солонгост эм зүйч, уламжлалт анагаах ухааны эм зүйч, эмийн үйлдвэрийн инженер гэсэн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байна.
3. Ажил үүргийн тухайд Монгол Улсад эм найруулагч мэргэжлээр дипломын боловсрол тусад нь олгодог бол Солонгос Улсад эм найруулагчийг тусад нь бэлтгэдэггүй эм зүйч хүн эм найруулах зөвшөөрөл авснаар эм найруулж болохыг хуулиндаа тусгасан боловч эм найруулгын ажлыг ихэвчлэн эмийн үйлдвэрт бэлтгэдэг болохыг тодруулав.
4. Мэргэжлийн салбарын тухайд Монгол Улсад эм зүйч мэргэжилтэн эмийн үйлдвэрт ажилладаг бол Солонгос Улсад эмийн үйлдвэрийн инженерийг тусад нь бэлтгэн гаргаж байна.
5. Солонгос Улсад эм зүйч мэргэжилтнийг өрхийн эм зүйч, цэргийн эм зүйч, цөмийн болон хорт хавдрын мэргэшсэн эм зүйч, эмгэг судлал, хор судлалын гэх мэтчилэн илүү нарийн мэргэшүүлж байна.
6. Солонгос Улсад төрийн албаны болон олон нийтийн байгууллагын эм зүйч гэсэн тусдаа статустай эм зүйчид ажилладаг бөгөөд үүнд хуулийн мэргэжилтэй эм зүйч байх шаардлага тавигддаг нь онцлог байна.

Ном зүй

Монгол хэлээр

1. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого. 2014
2. Монгол Улсын стандарт, Эмийн санд тавигдах шаардлага MNS 5260:2015.
3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль. 2010
4. Эм зүйч, эм найруулагчийн ёс зүйн хэм, хэмжээ эрх, үүрэг. 2016
5. Монгол Улсын стандарт, Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Эм зүй.2012

Солонгос хэлээр

1. БНСУ-ын Эм зүйчийн тухай хууль, 2015
2. <https://namu.wiki/w>
3. <https://ko.wikipedia.org/wiki>
4. www.google.com, www.naver.com

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
 ЭЗУ-ы доктор Л.Уламбаяр